



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/71

Арвайхээр

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Богд сумын Цаг уурын станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Н.Ганболд Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын дарга

Нарийн бичгийн дарга: - Т.Эрдэнэсүрэн Аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газрын ажил худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: -Ж.Бадамгарав Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Ц.Навчаа Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Ш.Авирмэд (Бүтээлч хөгжлийн хөтөч ТББ-ын гишүүн) (зөвшилцсөнөөр)

2. Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан мэдэгдэл, гэрээний төслийг өргөн мэдүүлэхийг Үнэлгээний хороо (Н.Ганболд)-д даалгасугай.

3. Тендер шалгаруулалттай холбоотой баримт бичгээр хууль, тогтоомжийн дагуу архивын нэгж бүрдүүлж архив-бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Т.Эрдэнэсүрэн)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100164